



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/815

Булган сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Дэлгэртэрэм” ХХК (РД:3188949)-д Булган сум 6 дугаар баг Залуус 18 дугаар гудамж 1806в тоотод байршилтай 576 м2 газрыг, Булган сум 6 дугаар баг Залуус 18 дугаар гудамж 1805а тоотод байршилтай 1490 м2 газрыг тус тус худалдаа үйлчилгээ зориулалтаар, иргэн Н.Дэмчигсүрэн (ФА68102671)-д Булган сум 5 дугаар баг Анхдагчдын өргөн чөлөө 1 дүгээр гудамжинд байршилтай 32 м2 газрыг автомашины гараашийн зориулалтаар, иргэн С.Зоригтбаатар (ГЮ67122511)-т Булган сум 5 дугаар баг Чин Ван Ханддоржийн өргө чөлөө 2 дугаар гудамж 200а тоотод байршилтай 86 м2 газрыг үйлчилгээний зориулалтаар газрын дуудлага худалдааны анхны үнийг төлүүлэн 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. “Дэлгэртэрэм” ХХК болон иргэн Н.Дэмчигсүрэн, С.Зоригтбаатар нартай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг “Дэлгэртэрэм” ХХК болон иргэн Н.Дэмчигсүрэн, С.Зоригтбаатар нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ